



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/184/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү, нийцлийн газрын захирал,
тэргүүлэх аудитор: **Ц.Наранчимэг**
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: **Э.Энхбаатар**
Утас: 51-260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: **С.Бат-Эрдэнэ**
Утас: 51-261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn
Аудитор: **П.Ариунзаяа**
Утас: 51-261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦЭНГЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 07/637
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр 4,939,232.9 мянган төгрөгийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан, 6,000.0 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, 1,677,334.9 мянган төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашигладаггүй илүүдэл хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.3.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар “Төрийн өмчийн удирдлагын мэдээллийн систем, дэд бүтэц” төсөл арга хэмжээнд 1,200,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийн хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээний 780,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж бэлтгэх 280,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

"Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын нэгдсэн систем"-ийн хөгжүүлэлтийн үе шатны ажил дуусаагүй, системийг дараагийн тайлант онд үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ТӨБЗГ-ын 2024 оны 351 дүгээр тогтоолоор 50 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс улсын төсөвт 641,470,208.4 мянган төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 83.5 хувь буюу 535,720,522.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,828,369,573.61 | 3,028,474,384.81 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 42,300,000.00 | 213,007,000.00 |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 42,300,000.00 | 213,007,000.00 |
| 31210 | Төгрөг | 42,300,000.00 | 213,007,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 42,300,000.00 | 213,007,000.00 |
| 33 | АВЛАГА | 22,422,585.82 | 200,994.02 |
| 33500 | Бусад авлага | 22,422,585.82 | 200,994.02 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 22,422,585.82 | 200,994.02 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 1,059,970,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 1,059,970,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 86,312,119.02 | 77,961,522.02 |
| 35400 | Хангамжийн материал | 86,312,119.02 | 77,961,522.02 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 13,273,407.02 | 11,631,010.02 |
| 35420 | Аж ахуйн материал | 298,440.00 | 298,440.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,693,800.00 | 6,760,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 68,046,472.00 | 59,272,072.00 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 1,677,334,868.77 | 1,677,334,868.77 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 1,677,334,868.77 | 1,677,334,868.77 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,948,545,042.19 | 2,764,972,186.48 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,948,545,042.19 | 2,764,972,186.48 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,843,643,742.15 | 2,673,993,886.44 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,751,191,680.00 | 2,750,780,584.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (332,032,669.40) | (397,644,417.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 160,428,572.00 | 55,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (2,400,000.00) | (17,633,333.34) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 436,105,065.60 | 456,547,226.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (239,953,940.30) | (245,259,248.77) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 220,601,251.00 | 128,719,695.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (150,296,216.75) | (57,116,619.06) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 104,901,300.04 | 90,978,300.04 |
| 39301 | Программ хангамж | 68,615,000.00 | 68,615,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (25,559,499.96) | (39,482,499.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 61,845,800.00 | 61,845,800.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,776,914,615.80 | 5,793,446,571.29 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 8,213,645.00 | 165,554,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 8,213,645.00 | 165,554,000.00 |
| 41300 | Өглөг | 810,635.00 | 165,554,000.00 |
| 41360 | Бусад өглөг | 810,635.00 | 165,554,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 810,635.00 | 165,554,000.00 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 7,403,010.00 | - |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 7,403,010.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,768,700,970.80 | 5,627,892,571.29 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,768,700,970.80 | 5,627,892,571.29 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 35,655,560.00 | 35,655,560.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 35,655,560.00 | 35,655,560.00 |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|--------------|--|-------------------------|-------------------------|
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 4,334,978,875.85 | 5,194,170,476.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,801,529,116.72 | 4,253,288,399.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,533,449,759.13 | 940,882,077.19 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 398,066,534.95 | 398,066,534.95 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,776,914,615.80 | 5,793,446,571.29 |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|---------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 456,625,516,572.20 | 48,231,468,900.68 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 454,591,567,512.20 | 44,309,354,800.68 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 453,719,034,152.33 | 44,082,859,050.68 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 448,361,142,638.42 | 40,073,832,984.68 |
| 120003 | Торгуулийн орлого | 37,207,300.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,000,000.00 | 5,000,041.36 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,000,000.00 | 5,000,041.36 |
| 120005 | Түрээсийн орлого | 3,453,445,373.14 | 3,852,277,544.97 |
| 120009 | Бусад орлого | 3,600,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 181,303,972.00 | 151,748,479.67 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,677,334,868.77 | - |
| 121 | Хөрөнгийн орлого | 872,533,359.87 | 226,495,750.00 |
| 121002 | Өмч хувьчлалын орлого | 872,533,359.87 | 226,495,750.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,033,949,060.00 | 3,922,114,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,849,205,300.00 | 3,788,043,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,849,205,300.00 | 2,728,073,600.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 1,059,970,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 184,743,760.00 | 134,070,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 184,743,760.00 | 134,070,500.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 455,092,066,813.07 | 47,204,593,229.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 455,092,066,813.07 | 47,204,593,229.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,093,471,279.04 | 2,821,034,034.89 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,248,518,661.69 | 1,671,258,359.33 |
| 210101 | Үндсэн цалин | 776,447,997.76 | 987,472,901.95 |
| 210102 | Нэмэгдэл | 249,130,577.53 | 326,160,041.78 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 134,600,000.00 | 229,372,000.00 |
| 210104 | Урамшуулал | 88,340,086.40 | 128,253,415.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 155,395,272.21 | 204,749,447.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,833,747.21 | 139,648,285.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,375,693.82 | 16,706,103.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,843,355.01 | 8,313,451.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,460,838.56 | 8,151,988.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,881,637.61 | 31,929,619.33 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 66,020,613.00 | 81,507,377.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,631,903.00 | 17,465,447.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,111,160.00 | 17,553,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 29,228,400.00 | 25,218,350.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,647,900.00 | 5,458,380.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 8,401,250.00 | 15,811,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 102,205,061.60 | 318,684,335.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 173,958,050.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 102,205,061.60 | 144,726,285.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 192,455,730.11 | 278,931,651.42 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 179,834,630.11 | 265,728,428.42 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 13,800.00 | - |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|-------------|--|---------------------------|--------------------------|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 733,800.00 | 610,583.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 34,300.00 | 26,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 49,400.00 | 39,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,789,800.00 | 12,526,640.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 328,875,940.43 | 265,902,864.19 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,079,060.00 | 18,425,026.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,185,000.00 | 23,768,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 226,611,880.43 | 223,709,138.19 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 452,998,595,534.03 | 44,383,559,194.11 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 109,267,627.00 | 188,391,634.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,825,613.00 | 68,472,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 37,642,014.00 | 39,476,514.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 61,800,000.00 | 80,442,320.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 452,889,327,907.03 | 44,195,167,560.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,109,523.99 | 28,502,698.66 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 452,885,218,383.04 | 44,166,664,861.45 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,533,449,759.13 | 1,026,875,671.68 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 85,993,594.49 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 85,831,111.07 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | - | 162,483.42 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 1,533,449,759.13 | 940,882,077.19 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|---------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 454,966,467,443.04 | 48,287,733,002.81 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 452,932,518,383.04 | 44,365,618,902.81 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 452,059,985,023.17 | 44,139,123,152.81 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 448,361,142,638.42 | 40,073,832,984.68 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,000,000.00 | 5,000,041.36 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,000,000.00 | 5,000,041.36 |
| 120005 | Түрээсийн орлого | 3,651,542,384.75 | 3,866,336,126.77 |
| 120009 | Бусад орлого | 42,300,000.00 | 193,954,000.00 |
| 121 | Хөрөнгийн орлого | 872,533,359.87 | 226,495,750.00 |
| 121002 | Өмч хувьчлалын орлого | 872,533,359.87 | 226,495,750.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,033,949,060.00 | 3,922,114,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,849,205,300.00 | 3,788,043,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,849,205,300.00 | 2,728,073,600.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 1,059,970,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 184,743,760.00 | 134,070,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 184,743,760.00 | 134,070,500.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 454,916,967,443.04 | 47,000,984,128.81 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 454,916,967,443.04 | 47,000,984,128.81 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,918,395,522.01 | 2,620,584,934.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,289,202,247.01 | 1,696,629,662.78 |
| 210101 | Үндсэн цалин | 733,455,680.26 | 934,496,841.62 |
| 210102 | Нэмэгдэл | 332,806,480.35 | 335,992,583.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 134,600,000.00 | 297,998,096.03 |
| 210104 | Урамшуулал | 88,340,086.40 | 128,142,141.80 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 154,690,500.00 | 207,400,128.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,090,500.00 | 141,038,936.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,900,000.00 | 16,751,535.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,320,000.00 | 8,355,967.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,579,900.00 | 8,250,737.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,800,100.00 | 33,002,950.99 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 57,028,000.00 | 64,757,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,829,400.00 | 12,848,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,453,800.00 | 19,620,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 29,228,400.00 | 24,887,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,516,400.00 | 7,402,480.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 93,469,142.00 | 318,684,335.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 173,958,050.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 93,469,142.00 | 144,726,285.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 191,230,530.00 | 282,800,302.42 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 178,001,430.00 | 269,317,079.42 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 13,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 733,800.00 | 610,583.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 34,300.00 | 26,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 49,400.00 | 39,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,397,800.00 | 12,806,640.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 132,775,103.00 | 50,312,726.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 121,625,103.00 | 26,314,026.00 |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|-------------|--|---------------------------|---------------------------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,150,000.00 | 23,998,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 452,998,571,921.03 | 44,380,399,194.11 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 109,244,014.00 | 185,231,634.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,802,000.00 | 65,312,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 37,642,014.00 | 39,476,514.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 61,800,000.00 | 80,442,320.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 452,889,327,907.03 | 44,195,167,560.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,109,523.99 | 28,502,698.66 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 452,885,218,383.04 | 44,166,664,861.45 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 49,500,000.00 | 1,286,748,874.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 7,200,000.00 | 1,116,041,874.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,200,000.00 | 1,116,041,874.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,200,000.00 | 1,116,041,874.00 |
| 220001 | Барилга байгууламж | - | 1,059,970,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,200,000.00 | 56,071,874.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (7,200,000.00) | (1,116,041,874.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 42,300,000.00 | 170,707,000.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 42,300,000.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 42,300,000.00 | 213,007,000.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл | 35,655,560.00 | 398,066,534.95 | 2,801,529,116.72 | 3,235,251,211.67 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 35,655,560.00 | 398,066,534.95 | 2,801,529,116.72 | 3,235,251,211.67 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,533,449,759.13 | 1,533,449,759.13 |
| 5 | 2023 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл | 35,655,560.00 | 398,066,534.95 | 4,334,978,875.85 | 4,768,700,970.80 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (81,690,476.70) | (81,690,476.70) |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 35,655,560.00 | 398,066,534.95 | 4,253,288,399.15 | 4,687,010,494.10 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | | | 940,882,077.19 | 940,882,077.19 |
| 9 | 2024 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл | 35,655,560.00 | 398,066,534.95 | 5,194,170,476.34 | 5,627,892,571.29 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|--|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,933,855,000.00 | 3,764,540,942.70 | 169,314,057.30 | 95.7 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,733,855,000.00 | 2,704,570,942.70 | 29,284,057.30 | 98.9 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,648,712,600.00 | 2,619,428,628.70 | 29,283,971.30 | 98.9 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,696,630,800.00 | 1,696,629,662.78 | 1,137.22 | 100.0 |
| Үндсэн цалин | 934,773,800.00 | 934,496,841.62 | 276,958.38 | 100.0 |
| Нэмэгдэл | 338,443,400.00 | 335,992,583.33 | 2,450,816.67 | 99.3 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 298,188,000.00 | 297,998,096.03 | 189,903.97 | 99.9 |
| Урамшуулал | 125,225,600.00 | 128,142,141.80 | (2,916,541.80) | 102.3 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 212,928,400.00 | 207,400,128.50 | 5,528,271.50 | 97.4 |
| Тэтгэврийн даатгал | 144,791,300.00 | 141,038,936.92 | 3,752,363.08 | 97.4 |
| Тэтгэмжийн даатгал | 17,034,200.00 | 16,751,535.16 | 282,664.84 | 98.3 |
| ҮОМШӨ-ний даатгал | 8,517,100.00 | 8,355,967.62 | 161,132.38 | 98.1 |
| Ажилгүйдлийн даатгал | 8,517,100.00 | 8,250,737.81 | 266,362.19 | 96.9 |
| Эрүүл мэндийн даатгал | 34,068,700.00 | 33,002,950.99 | 1,065,749.01 | 96.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 56,260,300.00 | 56,260,300.00 | - | 100.0 |
| Бичиг хэрэг | 7,848,000.00 | 7,848,000.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 19,620,000.00 | 19,620,000.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,887,300.00 | 23,887,300.00 | - | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,905,000.00 | 4,905,000.00 | - | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 324,392,400.00 | 318,684,335.00 | 5,708,065.00 | 98.2 |
| Гадаад албан томилолт | 177,242,400.00 | 173,958,050.00 | 3,284,350.00 | 98.1 |
| Дотоод албан томилолт | 147,150,000.00 | 144,726,285.00 | 2,423,715.00 | 98.4 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 300,846,800.00 | 282,800,302.42 | 18,046,497.58 | 94.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 285,388,900.00 | 269,317,079.42 | 16,071,820.58 | 94.4 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,471,500.00 | - | 1,471,500.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 880,000.00 | 610,583.00 | 269,417.00 | 69.4 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 191,300.00 | 26,800.00 | 164,500.00 | 14.0 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 39,200.00 | 39,200.00 | - | 100.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,875,900.00 | 12,806,640.00 | 69,260.00 | 99.5 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 57,653,900.00 | 57,653,900.00 | - | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 33,655,200.00 | 33,655,200.00 | - | 100.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 23,998,700.00 | 23,998,700.00 | - | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 85,142,400.00 | 85,142,314.00 | 86.00 | 100.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 85,142,400.00 | 85,142,314.00 | 86.00 | 100.0 |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | |
|---|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 45,665,800.00 | 45,665,800.00 | - | 100.0 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 39,476,600.00 | 39,476,514.00 | 86.00 | 100.0 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,200,000,000.00 | 1,059,970,000.00 | 140,030,000.00 | 88.3 |
| Дотоод эх үүсвэрээр | 1,200,000,000.00 | 1,059,970,000.00 | 140,030,000.00 | 88.3 |
| Барилга байгууламж | 1,200,000,000.00 | 1,059,970,000.00 | 140,030,000.00 | 88.3 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,938,855,000.00 | 3,769,540,984.06 | 169,314,015.94 | 95.7 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,933,855,000.00 | 3,764,540,942.70 | 169,314,057.30 | 95.7 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,733,855,000.00 | 2,704,570,942.70 | 29,284,057.30 | 98.9 |
| Хөрөнгийн санхүүжилт | 1,200,000,000.00 | 1,059,970,000.00 | 140,030,000.00 | 88.3 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 5,000,000.00 | 5,000,041.36 | (41.36) | 100.0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,000,000.00 | 5,000,041.36 | (41.36) | 100.0 |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | | |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 55 | 49 | 6 | 89.1 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 49 | 48 | 1 | 98.0 |
| Үйлчлэх ажилтан | 5 | - | 5 | - |
| ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 55 | 49 | 6 | 89.1 |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 44 | 40 | 4 | 90.9 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11 | 9 | 2 | 81.8 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-------------|--|------------|-----------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 134,070,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 134,070,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 53,628,180.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 8,497,480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 5,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 2,497,480.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 45,130,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 45,130,700.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 80,442,320.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 80,442,320.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 134,070,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 134,070,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 134,070,500.00 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 44,195,314.9 мянган төгрөгийн 2 алдаа илэрснээс, илэрсэн алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|---------------------|-----------------------------------|-----|--------------------------|---------------------|------------|---------------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд 44,166,914.9 мянган төгрөгийн орлогын тохируулга хийгээгүй байна. | 1 | 44,166,914.9 | | | 1 | 44,166,914.9 | 1 | 44,166,914.9 | | | | |
| Цалингийн сангаас ахмадын сангийн данс руу шилжүүлсэн 28,400.0 мянган төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайлангийн цалингийн зардлыг бууруулсан байна. | 1 | 28,400.0 | | | 1 | 28,400.0 | 1 | 28,400.0 | | | | |
| Дүн | 2 | 44,195,314.9 | - | - | 2 | 44,195,314.9 | 2 | 44,195,314.9 | - | - | - | - |

3.2 Аудитаар нийт 6,701,701.6 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс, 20,740.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 47,242.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 6,633,717.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-------------|---------------|-----|-----------------|-----|---------|-------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ТӨБЗГ-ын 2023 оны 623 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газруудад ашиглагдаж байсан 1,677,334.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг тус газрын санхүүгийн тайланд бүртгэсэн боловч 2024 онд дээрх хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, эрх бүхий байгууллагад саналыг хүргүүлээгүй байна. | 1 | 1,677,334.9 | | | | | 1 | 1,677,334.9 | | | | |
| Байгууллагын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгаагүй "Гамшгаас хамгаалах сургалт" өдөрлөг арга хэмжээг 2024 оны 09-р сарын 19-ний өдрөөс 22-ны өдрийн хооронд Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулж 17,150.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 17,150.0 | | | | | 1 | 17,150.0 | | | | |
| ТӨБЗГ нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ҮАГ-т 2025 оны А-1/163 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулга, тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр болон төсвийн тохируулгын тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|---|-------------|---|----------|---|-------------|--|--|--|--|--|--|
| ТӨБЗГ-ын даргын 2024 оны Б/54 дүгээр тушаалаар оны шилдэг 5 албан хаагчдад олгосон шагнал, цом худалдан авах зардлыг төсөвт зохицуулалт хийлгүүлэх зөвшөөрөлгүйгээр цалингийн зардлаас 6,000.0 мянган төгрөг олгосон байна. | 1 | 6,000.0 | | | 1 | 6,000.0 | | | | | | |
| ТӨБЗГ-ын даргын 2024 оны 351 дүгээр "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай" тогтоолоор 43 хуулийн этгээдээс 47,653,982.0 мянган төгрөгийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр хуулийн этгээдүүдтэй харилцан тохиролцож, баталсан боловч тайлант онд тус тогтоолд 2 удаа өөрчлөлт оруулсан байна. Үүнд: -ТӨБЗГ-ын 2024 оны 432 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн 1,713,147.7 мянган төгрөгийн ногдол ашгийг хүчингүй болгосон; -ТӨБЗГ-ын 2024 оны 738 дугаар тогтоолоор "Монголын төмөр зам" ХК-ийн улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг 3,226,085.2 мянган төгрөгөөр бууруулсан. | 1 | 4,939,232.9 | | | 1 | 4,939,232.9 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгаагүй ажил үйлчилгээ, бараа материалын худалдан авалтын гэрээг 4 хуулийн этгээдтэй байгуулж, гүйцэтгэлээр 16,300.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. | 1 | 16,300.0 | | | 1 | 16,300.0 | | | | | | |
| ТӨБЗГ-ын даргын Б/50 дугаар тушаалаар нэр бүхий 5 албан хаагчид тус бүр 4,988.5 мянган төгрөг, нийт 24,942.8 мянган төгрөгийн шагнал, үр дүнг давхардуулан олгосон байна. | 1 | 24,942.9 | | | 1 | 24,942.9 | | | | | | |
| ТӨБЗГ-ын 2024 оны "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой | 1 | 20,740.9 | 1 | 20,740.9 | | | | | | | | |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|----------|--------------------|----------|-----------------|----------|-----------------|----------|--------------------|----------|----------|----------|--|
| <p>хуулийн этгээдийн 2024 оны улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай " 351 дүгээр тогтоолоор 51 хуулийн этгээдээс 646,409,441.3 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна. Үүнээс: "Үндэсний баялгийн тухай хууль" батлагдаж, "Эрдэнэс монгол" ХХК-ний харьяа 8 хуулийн этгээдийн 598,755,459.29 мянган төгрөгийн ногдол ашгийг хуримтлалын санд хуримтлуулахаар хуульчлагдсан байна. Тайлант онд улсын төсвийн ногдол ашгийн дансанд 43 хуулийн этгээдээс 42,714,749.1 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 3 хуулийн этгээдэд ногдуулсан 2,640,205.2 мянган төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.Үүнд: "Монголын цахилгаан холбоо" ХК 3,129.3 мянган төгрөг , "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК 17,611.6 мянган төгрөг, "Эрчис ойл" ХХК 2,619,464.3 мянган төгрөг тус тус төвлөрүүлээгүй байна.</p> | | | | | | | | | | | | |
| <p>Өмнөх аудитаар тогтоосон ҮАГ-ын 2022 оны 23/АО171027 дугаартай "Монголросцветмет ТӨҮГ-аас Ирээдүй өв сан болон Улсын төсөвт төвлөрүүлэх 24,883,320.0 мянган төгрөгийн ногдол ашгийг төлүүлэх" төлбөрийн акт тогтоосныг 23,383,320.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, 2023 оны 09/АО171123 дугаартай "Цемент шохой" ТӨХК-аас Улсын төсөвт төвлөрүүлэх 5,815,347.9 мянган төгрөгийн ногдол ашгийг төлүүлэх" төлбөрийн актыг биелүүлээгүй байна.</p> | 1 | - | | 1 | - | | | | | | | |
| Дүн | 9 | 6,701,701.6 | 1 | 20,740.9 | 5 | 47,242.9 | 3 | 6,633,717.8 | - | - | - | |

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Нийцлийн асуудлаар нийт 3,353,863.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, түүнд 3 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|--------------------|--------------------------------------|----------|-----------------|--------------------|----------|----------|
| | | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,109,805.8 мянган төгрөгийн 17 гүйлгээ, зарлагын 456,102.5 мянган төгрөгийн 12 гүйлгээ, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 1,757,131.5 мянган төгрөгийн 46 мэдээллийг ил тод байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлж, ажиллаагүй байна. | 1 | 3,323,039.8 | | | 1 | 3,323,039.8 | | |
| Дүн | 1 | 3,323,039.8 | - | - | 1 | 3,323,039.8 | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нээлттэй тендер зарлаж "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийн тоног төхөөрөмж"-ийн 280,000.0 мянган төгрөгийн, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн систем, зөвлөх үйлчилгээ"-ний 779,970.0 мянган төгрөгийн, гэрээ байгуулсан боловч үндэслэлтэй бус шалтгаанаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, нийлүүлэлтийн хугацааг сунгасан байна. | 1 | - | | | 1 | - | | |
| ТӨБЗГ-ын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "Байгууллагын өөрийн хэрэгцээнд шаардлагатай компьютер техник" тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 30,823.8 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгслийн шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 30,823.8 | | | 1 | 30,823.8 | | |
| Дүн | 2 | 30,823.8 | - | - | 2 | 30,823.8 | - | - |
| Нийт дүн | 3 | 3,353,863.6 | - | - | 3 | 3,353,863.6 | - | - |